



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,

Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.08.06 № 1-6/609

танай _____-ны № _____-т

┌ ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМД

┌ Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох **“МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ”**-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817- 8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

↓ **“МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ”**-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ”-ын мөрийн хөтөлбөрийг хавсаргав.

Хувийг:Дорноговь аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт.....²хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

МАХН-ын нутгийн
хөтөлбөр
батлав



МАХН-ын Аймаг, сумдын ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Удирдах зөвлөлийн 2020 оны 06 сарын 16 өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

ЭРҮҮЛ ДОРНОГОВЬ ХӨТӨЛБӨР

Зорилго

МАХН нь орон нутгийн иргэдийнхээ ашиг, сонирхлыг удирдлага болгож, ардчилал, эрх чөлөөний үзэл санаанд тулгуурлан экологийн чиг баримжаатай нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгон эрүүл аюулгүй хотод амьдрах боломжийг бүрдүүлэхэд оршино. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд:

Орон нутгийн төр засгийн байгууллага, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүй өнөөгийн гаж тогтолцоог халж Монгол хүнийг хамгаалдаг иргэндээ ээлтэй нутгийн захиргааны шинэ тогтолцоонд шилжинэ.

“МАХН” нь эх оронч үзэлтэй мянга мянган шударга иргэдийн ирүүлсэн экологи, улс төр, соёл, эдийн засаг болон нийгмийн хөгжлийн өнөөгийн дүр төрхийг дүгнэсэн, улс эх орныхоо хөгжлийг хурдасгах өргөн хүрээтэй шийдвэртэй алхмуудыг санал болгож байна.

НЭГ. ИРГЭН ТАНЫ АМЬДРАЛД:

Иргэн та нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй Эрүүл хотод амьдран, сурч боловсрох эрхтэй.

- Төрийн болон хувийн хэвшлийн салбарт нас, хүйс, зүс царайгаар ялгаварлан гадуурхахыг зогсоох,
- Жирэмсэн эмэгтэйчүүд 3-5 насны хүүхэдтэй ажилчин, ажилтныг ажиллуулж буй аж ахуйн нэгжүүдийг татварын бодлогоор дэмжих,
- Иргэн бүр дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн дэвшилтэд тоног төхөөрөмж, технологи бүхий төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний зардлыг төр, иргэний зохистой харилцаагаар хариуцдаг тогтолцоог бий болгоно.
- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, дэмжих зорилгоор иргэд биеийн тамирыг хүн бүрийн амьдралын эрүүл дадал нөхцөл бололцоог нээхийн зэрэгцээ “ЭРҮҮЛ АМЬДРАЛ”, “ЭРҮҮЛ ХҮНС” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



ХОЁР. ӨРХ, ГЭР БҮЛИЙН АМЬДРАЛД:

Монгол Улсын тулгуур баялаг нь “Монгол өрх” мөн тул Улсын нийслэл, аймгийн төвүүдэд амьдарч буй өрх гэр, залуу гэр бүл, иргэдийг тохилог орон сууцанд амьдрах бодлогыг боловсруулан, өрх бүрийг орон сууцаар хангах зорилт тавьж ажиллана.

- Аймгийн төв, сумдад хувийн орон сууц барих бодлогыг дэмжин ажиллана.
- Малчин өрхийн малын үүлдэр, ашиг шимийг сайжруулах хөтөлбөрийг дэмжинэ.
- Бичил болон өрхийн бизнесийг дэмжих талаар аймгийн төвүүдэд зөвлөх үйлчилгээг үзүүлэх төвүүд байгуулах, нас насны онцлогт харгалзсан тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих санхүү, зээлийн төвүүдийг дэмжих зэрэг зорилтот бичил банк, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр айл өрх, аж ахуйн нэгжийн орлого, бизнесийн боломжийг нэмэгдүүлж, ажлын байрыг шинээр бий болгоно.

ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:

- Уул уурхай, хөрсний бохирдол, орчны бохирдол, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлэх
- Залуучуудад зориулсан гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэгч залуучуудад зориулсан “Залуу малчин” төвийг сум бүрт байгуулах
- Аймгийн төвүүдэд жил бүр 200 гарааны бизнесийг дэмжиж бойжуулах
- Ахмадуудыг төр засгийн байгууллагад зөвлөх мэргэжилтнээр ажиллуулах, тэднээс суралцах тогтолцоог хэрэгжүүлэх
- Аймаг, сумын төвүүдэд судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах, хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх
- Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- Зах зээлийн мэдрэмжтэй, хөрвөх чадвар сайтай, зохистой сүргийн, малжуулах зээлийг төр-арилжааны банкны хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлж, зээлийн дарамтнаас малчдыг чөлөөлөх боломжийг бүрдүүлэх,
- Сумдад “Цагаан алт” болох ноосыг боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих,



- Алслагдсан сумдын бэлчээрийг худаг усаар хангахад дэмжлэг үзүүлэх,
- Орон нутгийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүй, удирдлагын туслалцаа үзүүлэх, боловсон хүчний асуудал, бүс нутгийн МСҮТ боловсон хүчний сургалт дадлагажилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Хүүхдийн цэцэрлэг, сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэн хүүхдэд ээлтэй ногоон орчин бүрдүүлэх бодлогыг дэмжиж хэрэгжүүлэх,
- Багш нарыг орон сууцжуулах, хөдөө орон нутагт багшлах боловсон хүчнийг дэмжих, сургалтад хамруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор аймаг, сумын засаг даргын дэргэд “Багш” сан байгуулж ажиллуулах,
- Сумдын иргэдийн мэдээлэл, харилцаа холбоог сайжруулна.
- Аймаг, сумын засаг даргыг иргэд шууд сонгодог огтолцоог бий болгоно.

МАХН

